

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЦАХИМ СУРГАЛТЫН БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН ЗАРИМ ҮР ДҮН

Л.Отгонтөгс¹, М.Нарантуяа¹, Д.Алтайхүү¹,
¹АШУУИС-ийн Дархан-АУС

Түлхүүр үг: Сургалтын холимог загвар, мэргэжлийн онцлог, мэргэжлийн ур чадвар

Судалгааны үндэслэл:

Өнөө үеийн нөхцөл байдал нь боловсролын системийн өмнө шинэ, шинэ зорилтуудыг дэвшүүлэн тавьж улмаар цахим сургалтын үйл явц, чанар, суралцагчдын хэрэгцээ, хандлагыг судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа нь бидний судалгааны ажлын үндэслэл болно. Мөн түүнчлэн гадаад, дотоодын зарим их сургуулиудын цахим сургалтын үйл явц, чанар, суралцагчдын хэрэгцээ, хандлагыг хооронд нь харьцуулан үнэлэлт өгөх нь ихээхэн чухал юм.

Судалгааны ажлын зорилго:

Оюутны цахим сургалтын чанар, суралцагчдын хэрэгцээ, хандлагад судалгаа хийж, гадаад, дотоодын зарим их сургуулиудтай харьцуулан судалж үнэлэх.

Судалгааны зорилт:

1. Цахим сургалтын чанар, суралцагчдын хэрэгцээ, хандлагыг үнэлэх
2. Гадаад, дотоодын зарим их сургуулиудтай харьцуулах

Судалгааны арга зүй:

Санамсаргүй түүврийн аргаар санал асуулгын судалгаанд ОХУ-ын эрдэмтэд 2 их сургуулийн 200 оюутан хамруулсан бол бидний судалгаанд

Дархан-Уул аймаг дах 3 их сургуулийн 197 оюутан хамрагдсан байна.

Судалгаанд оролцогчдын үнэлгээг тодорхойлохдоо ОХУ-ын Астрахань мужийн АУИС (Астраханийн Улсын Их Сургууль), ААУУИС-ийн (Астраханийн Анагаахын Улсын Их Сургууль) эрдэмтдийн боловсруулж, оюутнуудын дунд явуулсан 10 асуулттай асуумжийн хуудас ашигласан ба бүх оюутнууд энэхүү үнэлгээний хуудсыг бөглөсөн.

Судалгааны объектуудын сонголт нь ОХУ-ын судлаачдын хувьд ч, бидний хувьд ч санамсаргүй биш бөгөөд нэг талаасаа өөр өөр мэргэжлийн хүрээнд цахим технологи хэрхэн ашиглаж буй байдлыг харьцуулах, нөгөө талаасаа тухайн үед цар тахлын хөл хорионы үед бүхий л сургалт цахим хэлбэрт бүрэн шилжсэн нийтлэг үзэгдэлтэй холбоотой юм.

Үр дүн:

Цахим сургалтын чанарыг үнэлэхдээ нийт оюутнуудын талаас дээш хувь (52.2%-86.7%) нь хичээлийн агуулгад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн бол ОХУ-ын ААУУИС-ийн оюутнуудын 12.5%, АУИС-ийн оюутнуудын 13.3%, Дархан-Уул аймаг дахь АУС-ийн оюутнуудын 14.9%, Дарханы ТИС, АЭИС-ийн оюутнуудын 14.4% нь хичээлийн агуулгад бүрэн сэтгэл хангалуун бус байгаагаа (Хүснэгт 1) тус тус илэрхийлсэн байна.

Хүснэгт №1 Цахим хичээлийн агуулгад өгсөн суралцагчдын үнэлгээ, хувиар

Үнэлгээ	Дархан-АУС	Дархан-бусад	Астрахань-ААУИС	Астрахань-АУИС
Бүрэн сэтгэл хангалуун	18.8%	18.9%	50.0%	60.0%
Ихэнхдээ сэтгэл хангалуун	37.4%	33.3%	12.5%	26.7%
Ихэнхдээ сэтгэл хангалуун бус	28.9%	33.3%	12.5%	0.0%
Бүрэн сэтгэл хангалуун бус	14.9%	14.4%	12.5%	13.3%

Судалгаанд оролцогчид их сургуулиудын цахим сургалтын хэтийн төлөвийн талаар санал бодлоо илэрхийлсэнээс харвал ихэнх нь цахим сургалтад эерэг хандлагатай байсан ба тэдгээрийн 58-86.7 хувь нь цар тахлын өвчлөл буурсан ч цахим сургалтын эзлэх хувь цаашид хэвээр үргэлжлэх эсвэл нэмэгдэх байх гэж үзсэн байна.

Харин сонирхол татаж буй хариулт бол ямар ч үед цахим сургалт огт дэмий сургалтын хэлбэр гэж үзсэн оюутнууд бөгөөд тэдгээр нь дунджаар 14 орчим хувийг эзэлж байна. Энэ үнэлгээ нь судалгаанд оролцогчдын өөрсдийн суралцах

бэлтгэл хангалтгүйг харуулж буй үзүүлэлт бөгөөд оюутнууд цахим сургалтад хангалттай дасан зохицсон байх нь өнөө үеийн шаардлага гэдгийг онцлох нь зүйд нийцнэ.

Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж үзэхэд цахим сургалтад шилжих явцыг сургуулиуд өөр өөр байдлаар үнэлсэн хэдий ч хөл хорионы үеэрх цахим сургалтын үед “хичээл заах чадвар” өөрчлөгдөөгүй гэж оюутнуудын 52-100 хувь үзсэн (Хүснэгт 2) бол 44.6-73.4 хувь нь мэргэжлийн ур чадварт суралцахад, 68.4-86.7 хувь нь багшийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй гэж хариулсан байна.

Харин АУИС-д суралцагчдын 2 оюутан тутмын нэг нь буюу 50 хувь нь, Дархан-АУС-ийн 41.4 хувь цахим сургалтаар тухайн хичээлээр эзэмшвэл

зохих чадвар буурсан гэж үзсэн нь тухайн мэргэжлийн онцлогоос хамаарсан байна.

Хүснэгт 2. Цахим сургалтын үеийн оюутнуудын үнэлгээ

Үнэлгээ	ДАУС/ТИС, АЭИС/ /ААУИС/АУИС муудсан	ДАУС/ТИС, АЭИС/ /ААУИС/АУИС өөрчлөгдөөгүй	ДАУС/ТИС, АЭИС/ /ААУИС/АУИС сайжирсан
Хичээл заах чадвар	28/26/25/0	52/56/75/100	20/18/0/0
Мэргэжлийн ур чадвар эзэмшилт	41.4/30.6/50/13.3	44.6/54.4/50/73.4	14/15/0/13.3
Лекц, дадлагын хичээлийн чанар	21.2/20.4/25/26.6	48.8/46.4/50/39.9	30/34.6/25/13.3
Багшийн үнэлгээний бодит байдал	10.4/11.6/12.5/0	68.4/70.2/77.5/86.7	21.2/18.8/0/13.3

Анагаахын мэргэжлийн бус оюутнуудын хувьд давуу талыг хүртээмж ба нээлттэй байдал, хичээлийн хуваарийн уян хатан, чөлөөт байдлыг илүүд үзсэн бол анагаахын сургуулийн оюутнуудын

хувьд хичээлийн уян хатан, зэрэгцээ суралцах боломж, бие даасан байдлыг илүү чухалчилсан (Хүснэгт 3) байна.

Хүснэгт 3. Цахим сургалтын давуу тал

Астрахань-АУИС	Астрахань-ААУИС	Дархан-АУС	Дархан-ТИС, АЭИС
Хүртээмжтэй ба нээлттэй байдал	Уян хатан, зэрэгцээ суралцах боломж	Уян хатан, зэрэгцээ суралцах боломж	Хүртээмжтэй ба нээлттэй байдал
Хуваарийн уян хатан, чөлөөтэй байдал	Хуваарийн уян хатан, чөлөөтэй байдал	Суралцах бие даасан байдал	Суралцах бие даасан байдал
	Суралцах бие даасан байдал	Хуваарийн уян хатан, чөлөөтэй байдал	Хуваарийн уян хатан, чөлөөтэй байдал

Энэ нь анагаахын мэргэжлийн оюутнуудын хувьд мэргэжлийн онцлогийн үүднээс хичээлүүдээ цогц байдлаар, зэрэгцээ болон залгамж холбоогоор судлах нь илүү чухал гэж үзсэнтэй холбоотой юм. Судалгаанд хамрагдсан оюутнууд нь цахим

сургалтын сул талыг оюутнуудын 62-оос дээш хувь нь “Багштай шууд харилцах боломж хомс” (Хүснэгт 4) гэдгийг онцолсон нь анхаарал татаж байна.

Хүснэгт 4. Цахим сургалтын сул тал

Астрахань-АУИС	Астрахань-ААУИС	Дархан-АУС	Дархан-ТИС, АЭИС
Багштай шууд харилцах боломж хомс	Багштай шууд харилцах боломж хомс	Багштай шууд харилцах боломж хомс	Багштай шууд харилцах боломж хомс
Хичээлээ бие даан эзэмшихэд хэцүү төвөгтэй болсон	Хичээлээ судлах явцад суралцах ачааллыг нэмэгдүүлсэн	Хичээлээ бие даан эзэмшихэд хэцүү төвөгтэй болсон	Хичээлээ судлах явцад суралцах ачааллыг нэмэгдүүлсэн
Хичээлээ судлах явцад суралцах ачааллыг нэмэгдүүлсэн	Хичээлээ бие даан эзэмшихэд хэцүү төвөгтэй болсон	Интернет, техник хангамжийн хүрэлцээ тааруу үед	Интернет, техник хангамжийн хүрэлцээ тааруу үед

Багштай шууд холбоо тогтоохгүйгээр хүндхэн, хэцүү асуудлаар зөвлөгөө авахгүйгээр шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмших боломжгүй юм.

Дүгнэлт:

1. Аль ч орны хувьд цахим сургалтад оюутнуудын ихэнх нь эерэг хандлагатай байгаа ба сургалтын холимог загвар бодит байдал нэвтэрч, улмаар цахим сургалтад дасан зохицож буй нь нийтлэг шинжийг илэрхийлж байна.

2. Цахим сургалтын үед тухайн хичээлээр эзэмшвэл зохих чадвар буурсан нь тухайн улс орноос бус мэргэжлийн онцлогоос хамаарсан байна.

3. Цахим сургалтын сул талыг нь багштай шууд харилцах боломж хомс байдлаар голлон илэрхийлэгдэж байгаа нь харьцуулагдаж буй улс орнууд, сургуулиудын хувьд нийтлэг байна.

4. Цахим сургалтыг ашиглах нь бүрэн боломжтой боловч зарим мэргэжлийн ур чадварт сөргөөр нөлөөлж болох учраас тухайн мэргэжлийн онцлогт тулгуурласан, харилцан адилгүй эзлэх хувьтай сургалтын холимог загварыг бий болгох, хэрэгжүүлэх, улам боловсронгуй болгоход анхаарах нь чухал юм.

Abstract

The article studies the practice of using distance learning by universities in Darkhan in a pandemic; the views of medical students and students of other professions on the quality and prospects of distance education, as well as the impact of distance learning on the developed online courses on the level of satisfaction and mastery of academic disciplines have been studied.

The results of this study were also compared with the results of scientists from the universities of Astrakhan.

The purpose of the article is to study the disadvantages and advantages of distance learning at the university and determine the main trends and prospects for its development. During the research, general scientific methods, questionnaires, grouping, classification, structural analysis, comparative analysis, graphical method were used.

The majority of students consider distance education to be advisable only within the framework of a mixed educational model, along with the traditional one. Distance education attracts the student audience with flexibility, accessibility and a free learning schedule. It is, on the one hand, an innovative and promising direction in the development of the education system in Russia and Mongolia. But, on the other hand, it can be most successfully applied in the training of specialists only in conjunction with the methods of traditional teaching.

Ном зүй

- Д.Алтайхүү, Л.Отгонтөгс, Л.ОюунЭрдэнэ 2020 Мэдээллийн технологийн хөгжил ба дээд боловсрол. Дээд боловсрол-Эрин үе сэтгүүл. №4. 32-37
- П.Одонжил 2021 Оюутны цахим сургалтын сэтгэл ханамжид хийсэн судалгаа.
- О.Н. Антропова и др (2021) Исследование практики дистанционного обучения в вузах в условиях пандемии. Мир науки, культуры, образования. № 1 (86) 104-106
- Gil-Jaurena I., Domínguez D. Teachers' Roles in Light of Massive Open Online Courses (MOOCs): Evolution and Challenges in Higher Distance Education. *International Review of Education*. 2018; Vol. 64, № 2: 197 – 219
- Айдрус И.А., Асмятуллин Р.Р. Мировой опыт использования технологий дистанционного образования. Высшее образование в России. 2015; № 5: 139 – 145. [3; 4].
- Галиханов М.Ф., Хасанова Г.Ф. Подготовка преподавателей к онлайн-обучению: роли, компетенции, содержание. Высшее образование в России. 2019; Т. 28, № 2: 51 – 62.